

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.. оны ... дугаар сарын ...-ний өдөр

Улаанбаатар хот

### ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ДЭД БҮТЦИЙН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### **1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах, орон зайн өгөгдлийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх, хэрэглэх үйл ажиллагааг удирдах, зохион байгуулах, хяналт тавих, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### **2 дугаар зүйл.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хууль тогтоомж**

2.1.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Харилцаа, холбооны тухай хууль, Иргэний хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

##### **3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрийг дүрсэлсэн, тоон хэлбэр бүхий орон зайн өгөгдлийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх, хэрэглэх үйл ажиллагаанд оролцогч төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэнд хамаарна.

3.2.Нууцад хамаарах орон зайн өгөгдлийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг Төрийн болон албаны нууцын тухай хуулиар зохицуулна.

##### **4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“геопортал” гэж интернэтэд суурилсан орон зайн өгөгдлийг хайх, харах, засварлах, дүн шинжилгээ хийх боломж бүхий цахим үйлчилгээ үзүүлэх веб порталыг;

4.1.2.“геоплатформ” гэж геопорталаар дамжуулан орон зайн өгөгдлийг түгээж буй программ хангамж, техник хангамж, технологийн шийдлийн цогцыг;

4.1.3.“иргэн” гэж Иргэний хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дах хэсэгт заасныг;

4.1.4. “хуулийн этгээд” гэж Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасныг.

4.1.5. “хандах эрх” гэж геоплатформд байгаа орон зайн өгөгдөлд хандахад эрх бүхий байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд олгож буй нэвтрэх эрхийн зөвшөөрлийг;

4.1.6. “үйлчилгээний хураамж” гэж иргэн, хуулийн этгээд геопорталаас төлбөртэй үйлчилгээ, лавлагаа авахад төлөх төлбөрийг;

4.1.7. “мета-өгөгдөл” гэж орон зайн өгөгдлийг хайх, бүртгэх, ашиглахад зориулагдсан орон зайн өгөгдлийн тухай мэдээллийн цогцыг;

4.1.8. “орон зайн өгөгдөл” гэж газрын гадаргын дээрх, доорх, ус, агаар, сансрын орон зайд орших байгалийн болон хүний үйл ажиллагаагаар бүтээгдсэн биет юмс, үзэгдлийн байрлал, хил, түүний шинж чанарыг тодорхойлсон мэдээллийн цогцыг;

4.1.9. “суурь орон зайн өгөгдөл” гэж дэлхийн гадаргаас шууд хэмжигдэх буюу хүний нүдэнд харагдах харьцангуй урт хугацаанд үл өөрчлөгдөх орон зайн өгөгдлийг;

4.1.10. “сэдэвчилсэн орон зайн өгөгдөл” гэж суурь орон зайн өгөгдөлд үндэслэсэн, хил хамгаалах болон батлан хамгаалах, хуулиар төрийн нууцад хамаарах мэдээллийг агуулаагүй орон зайн бусад өгөгдлийг;

4.1.11. “орон зайн өгөгдлийн дэд бүтэц” гэж орон зайн өгөгдлийг бүрдүүлэгч, хэрэглэгч, эдгээрийн хамтын ажиллагааг удирдан зохион байгуулах хууль, тогтоомж, бодлого, стандарт, техник, технологи, хүний нөөцийн цогцыг;

4.1.12. “орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаа” гэж орон зайн өгөгдлийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх, хэрэглэх цогц үйл ажиллагааг.

## **5 дугаар зүйл. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн талаар баримтлах зарчим, түүнийг хэрэгжүүлэх**

5.1. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

5.1.1. өгөгдөл ил тод, хүртээмжтэй байх;

5.1.2. экологи, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд чиглэсэн байх;

5.1.3. нэгдмэл, оновчтой, үр ашигтай байх;

5.1.4. төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих;

5.1.5. инновацад суурилах.

5.2. Энэ хуулийн 5.1.1-д заасан өгөгдөл ил тод, хүртээмжтэй байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

5.2.1. орон зайн өгөгдлийг бүрдүүлэгч нь төрийн нууцад хамааруулсан мэдээллийг агуулж буй орон зайн өгөгдлөөс бусад өгөгдлийг дамжуулж, ашиглах боломж нөхцөлөөр хангах;

5.2.2. орон зайн өгөгдлийг түгээгч нь өгөгдлийн шинэчлэл, өөрчлөлтийн талаар тогтмол мэдээлэх;

5.2.3. мета-өгөгдлийг тухай бүр шинэчлэх;

5.2.4. сонгон шалгаруулах ажиллагаа, түншлэлийн арга, хэлбэр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, холбогдох төрийн байгууллагаас гаргасан шийдвэр, хувийн хэвшлийн этгээдийг, түншлэлийн үр дүн нийтэд ил тод, нээлттэй байх.

5.3. Энэ хуулийн 5.1.2-д заасан экологи, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд чиглэсэн байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

5.3.1. ногоон хөгжлийн бодлогод нийцсэн системийн шийдлийг нэвтрүүлэх;

5.3.2. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн мета-өгөгдлийн сангийн үйлчилгээтэй байх;

5.3.3. гамшиг, онц байдал, гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас орон зайн өгөгдлийн дэд бүтцэд учрах эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах төлөвлөгөөтэй байх.

5.4. Энэ хуулийн 5.1.3-д заасан нэгдмэл, оновчтой, үр ашигтай байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

5.4.1. энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан зохицуулах хороо нь төрийн байгууллагуудаас орон зайн өгөгдлийг бүрдүүлэх чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл хөтөлбөрүүд төрөөс баримтлах бодлого, хууль, тогтоомжид нийцэж байгаа эсэхэд үнэлгээ хийж, саналаа хүргүүлсэн байх;

5.4.2. төрийн байгууллага улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр энэ хуулийн 6.4-т заасан мэдээллийг өөрчлөх, баяжуулах, хэрэглэх чиглэлээр төсөл, хөтөлбөрийг төлөвлөхдөө зохицуулах хорооны саналыг авсан байх;

5.4.3. төсөл хэрэгжүүлэгч нь энэ хуулийн 5.4.2-т заасан саналаас хуульд заасан үндэслэлээр 1 удаа татгалзах эрхтэй ба энэ тохиолдолд зохих тайлбарыг хийсэн байх;

5.4.4. төрийн байгууллага, түүний харьяа нэгж нь бүрдүүлсэн орон зайн өгөгдлөө геоинформатик төвлөрүүлэх;

5.5. Энэ хуулийн 5.1.4-д заасан төр, хувийн хэвшлийн түншлэлийг дээшлүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

5.5.1. төрөөс энэ хуулийн 14.8-д зааснаас бусад хувийн хэвшилтэй хамтран ажиллах тохиолдолд түүнийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр сонгох;

5.5.2. энэ хуулийн 5.5.1-т заасан үндэсний хувийн хэвшлийн хүний нөөцийг бэхжүүлэх, шинэ технологи, аргачлалаар хангах замаар дэмжих;

5.6.Энэ хуулийн 5.1.5-д заасан инновацад суурилах зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

5.6.1.орон зайн өгөгдөл солилцоог олон улсын түвшинд гаргаж, улсын хилийн гаднах орон зайн өгөгдлийг геоплатформд төвлөрүүлэх;

5.6.2.монгол улсын олон улсын өмнө хүлээсэн эрх, үүрэгт 3-5 жил тутамд дүн шинжилгээ хийх;

5.6.3.нээлттэй эх үүсгэвэр бүхий орчныг бүрдүүлж, хөгжүүлэлтийг тогтмол хийх;

5.6.4.хаалттай эх үүсгэвэр бүхий орчинд ажиллах, хаалттай эх код бүхий программ хангамж, бусад хэрэгслийг нээлттэй өгөгдлийн талаар төрөөс баримтлах бодлогод нийцүүлэн зохистой хэмжээнд нэвтрүүлэх.

5.7.Орон зайн өгөгдөл нь дараах шаардлагыг хангасан байна:

5.7.1.бүрэн байх;

5.7.2.нэгдмэл байх;

5.7.3.уялдаатай байх;

5.7.4.шинэлэг байх;

5.7.5.үнэн зөв, бодитой байх;

5.7.6.зорилгод нийцсэн нарийвчлал хангахуйц байх;

5.7.7.давхардалгүй байх;

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН АНГИЛАЛ, ТӨРӨЛ, ДҮРСЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ, ТЭДГЭЭРИЙН БҮРДЭЛ**

### **6 дугаар зүйл.Орон зайн өгөгдлийн ангилал**

6.1.Орон зайн өгөгдөл нь суурь орон зайн өгөгдөл болон сэдэвчилсэн орон зайн өгөгдөл гэсэн ангилалтай байна.

6.2.Орон зайн өгөгдөл нь вектор, растер гэсэн өгөгдлийн төрөлтэй байна.

6.3.Орон зайн вектор өгөгдөл нь цэг, шулуун, полигоноор дүрслэгдэнэ.

6.4.Суурь орон зайн өгөгдөл нь дараах өгөгдлөөс бүрдэнэ.

6.4.1.геодезийн байнгын цэг тэмдэгтийн;

6.4.2.байр зүйн зургийн;

6.4.3.газар зүйн нэрийн;

6.4.4.газар ашиглалтын;

- 6.4.5.газрын бүрхэвчийн;
- 6.4.6.барилга байгууламжийн;
- 6.4.7.дэд бүтцийн;
- 6.4.8.зам тээврийн сүлжээний;
- 6.4.9.инженер-геологийн;
- 6.4.10.кадастрын нэгж талбарын;
- 6.4.11.орто-зураглалын;
- 6.4.12.өндрийн;
- 6.4.13.түүх, соёл, ареологийн өвийн;
- 6.4.14.ус зүйн;
- 6.4.15.хаягийн;
- 6.4.16.хил заагийн;
- 6.4.17.хөрсний;
- 6.4.18.хүн ам, нийгмийн;

6.5.Энэ хуулийн 6.4-т заасан суурь орон зайн өгөгдөл нь дараах мэдээллийг агуулсан байна:

6.5.1.геодезийн байнгын цэг тэмдэгтийн өгөгдөл нь навигацийн, лазерын хиймэл дагуул, маш урт суурь талын интерферометр болон бусад астрономи-геодезийн аргаар 3 хэмжээст орчинд цэгийн байрлал, хүндийн хүчийг цаг хугацааны хамааралтайгаар тодорхойлсон 3 болон түүнээс дээш утгыг;

6.5.2.байр зүйн зургийн өгөгдөл нь Геодези, зураг зүйн тухай хуульд заасан шаардлагыг хангасан газрын гадаргыг бүхэлд нь, хэсэгчлэн дүрсэлсэн, бүх масштабын газрын зургийн мэдээллийг;

6.5.3.газар зүйн нэрийн өгөгдөл нь Геодези, зураг зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дах хэсэгт заасан мэдээллийг;

6.5.4.газар ашиглалтын өгөгдөл нь Газрын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан газрын нэгдмэл сангийн ангиллын мэдээлэл, хүний гараар бүтсэн объектын мэдээллийг;

6.5.5.газрын бүрхэвчийн өгөгдөл нь хөдөө аж ахуйн талбай, ой, байгалийн цогцолборт газар, ус зэрэг дэлхийн гадаргын физик болон биологийн бүрхэвчийн мэдээллийг;

6.5.6.барилга байгууламжийн өгөгдөл нь барилга, байгууламж, үл хөдлөх хөрөнгө, байгаль, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаа явагдаж буй хүн ам суурьшсан газрын байршил, өвөлжөө, хаваржааны мэдээллийг;

6.5.7.дэд бүтцийн өгөгдөл нь харилцаа холбоо, эрчим хүч, дулаан дамжуулах сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам, ус зайлуулах шугам, үерийн далан, суваг, тэдгээрт хамааралтай барилга, байгууламжийн мэдээлэл, нийгмийн дэд бүтцийн мэдээллийг;

6.5.8.зам тээврийн сүлжээний өгөгдөл нь авто зам, хотын гудамж, гудам, жим, явган хүний зам, дугуйн зам, төмөр зам, өртөө, усан зам, агаарын зам, онгоцны буудал, аэродром, болон тээврийн сүлжээнд хамаарах гүүр, далан, байгууламж, төлөвлөсөн замын батлагдсан чигийн мэдээллийг;

6.5.9.инженер-геологийн өгөгдөл нь Газрын хэвлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан газрын хэвлийн мэдээлэл, инженер геологи, гидрогеологи, ашигт малтмалын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан ашигт малтмалын ордын мэдээллийг;

6.5.10.кадастрын нэгж талбарын өгөгдөл нь Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд заасан эдлэн газар, нэгж талбарын байршил, хэмжээ, газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн төрлийн зориулалт, үнэлгээ, төлбөр, татварын мэдээллийг;

6.5.11.орто-зураглалын өгөгдөл нь хиймэл дагуул, агаарын хөлгөөс авсан дэлхийн гадаргууг дүрсэлсэн геометрийн засвар хийгдсэн растер зургийн мэдээллийг;

6.5.12.өндрийн өгөгдөл нь хуурай газрын гадаргуугийн мэдээллийг;

6.5.13.түүх, соёл, археологийн өвийн өгөгдөл нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар соёлын өвийн бүртгэлд бүртгэгдсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгал, түүний хамгаалалтын бүс, хамгаалалтын бүс тогтоосон дурсгалт газрын мэдээллийг;

6.5.14.ус зүйн өгөгдөл нь гол, мөрөн, нуур, цөөрөм, горхи, худаг, рашаан, булаг, шанд, усан сан, мөстөл, мөсөн голын мэдээллийг;

6.5.15.хаягийн өгөгдөл нь газар нутаг, хот, суурин газрын гудамж, зам, талбай, бүх шатны төрийн байгууллага, түүний салбар нэгж, төрийн бус байгууллага, сүм, хийд, үйлдвэр, аж ахуйн нэгж, хотхон зэрэгт хамаарах үл хөдлөх эд хөрөнгийн байршлын мэдээллийг;

6.5.16.хил заагийн өгөгдөл нь засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хил, Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан тусгай хэрэгцээний газрын хил, бүсчлэлийн хил, байгалийн бүслүүр болон байгаль, нийгэм, эдийн засгийн бусад хил, заагийн мэдээллийг;

6.5.17.хөрсний өгөгдөл нь Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх дэд хэсэгт заасныг;

6.5.18.хүн ам, нийгмийн өгөгдөл нь Статистикийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь дэд хэсэгт хамаарах, энэ хэсэгт тусгайлан заагаагүй бусад мэдээллийг;

6.6.Суурь орон зайн өгөгдлөөс бусад орон зайн өгөгдөл нь сэдэвчилсэн орон зайн өгөгдлийн ангилалд хамаарна.

6.7.Геоплатформд агуулагдаж буй орон зайн өгөгдөл нь төрийн өмч бөгөөд ба улсын бүртгэлийн мэдээллийн үндэс байна.

## **7 дугаар зүйл.Орон зайн өгөгдлийн мета-өгөгдөл**

7.1.Орон зайн өгөгдлийг бүрдүүлэх, боловсруулахад түүний мета-өгөгдлийг стандартын дагуу зэрэг бүрдүүлнэ.

7.2.Орон зайн өгөгдлийг геоплатформд байрлуулахдаа дор дурдсан мета-өгөгдлийг нээлттэй байлгана:

- 7.2.1.солбицлын тогтолцоо, тусгаг;
- 7.2.2.өгөгдлийн чанар;
- 7.2.3.өгөгдлийн төрөл;
- 7.2.4.орон зайн дүрслэл;
- 7.2.5.бүрдүүлсэн огноо;
- 7.2.6.мэдээний шинэчлэлт;
- 7.2.7.хариуцагч этгээд;
- 7.2.8.орон зайн мэдээллийг ашиглах эрх.

## **8 дугаар зүйл.Орон зайн өгөгдөлд хандах эрх**

8.1.Орон зайн өгөгдөлд хандах эрх түвшин нь дор дурдсан ангилалтай байна:

- 8.1.1.нээлттэй;
- 8.1.2.бизнесийн;
- 8.1.3.хөгжлийн бодлого төлөвлөлтийн;
- 8.1.4.онцгой байдал, гамшгийн;
- 8.1.5.үндэсний аюулгүй байдлын.

8.2.Энэ хуулийн 8.1.1, 8.1.2-т заасан хандах эрхийг зохицуулсан журмыг Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн зохицуулах хороо батална.

8.3.Энэ хуулийн 8.1.3-8.1.5-т заасан хандах эрхийг зохицуулсан журмыг Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн зохицуулах хорооны саналыг үндэслэн Засгийн газар батална.

8.4.энэ хуулийн 8.1.5-д заасан эрх бүхий этгээдийг геоплатформд байршсан бүх өгөгдлөөр саадгүй хангана.

8.5.Үндэсний аюулгүй байдлыг хангахад зориулсан тусгай геоплатформыг байгуулах, эрхлэх асуудлыг холбогдох хуулиар зохицуулна.

## **9 дүгээр зүйл. Үйлчилгээний хураамж**

9.1.Геопорталаас иргэн, хуулийн этгээд нь лавлагаа, төлбөртэй мэдээллийг харах, татах нөхцөлд үйлчилгээний хураамж төлнө.

9.2.Үйлчилгээний хураамжийн хувь хэмжээг энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан зохицуулах хороо тогтоож, төвлөрүүлнэ.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ДЭД БҮТЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **10 дугаар зүйл.Орон зайн өгөгдлийг бүрдүүлэх**

10.1.Орон зайн өгөгдлийг бүрдүүлэх гэдэгт түүнийг энэ хуулийн 15 дүгээр зүйлд заасан техникийн баримт бичигт заасны дагуу цуглуулах, шинэчлэх, өөрчлөх, тодотгох, баяжуулах үйл ажиллагаа хамаарна.

10.2.Орон зайн өгөгдлийн бүрдүүлэлт нь дараах аргад суурилна:

10.2.1.бүх төрлийн газрын хэмжилт, зураглал;

10.2.2.бүртгэл, тооллого;

10.2.3.шинжлэх ухаан, технологийн ололтод суурилсан бусад арга.

10.3.Орон зайн сэдэвчилсэн өгөгдлийг бүрдүүлэхдээ ашиглаж буй суурь орон зайн өгөгдлийн байрлал, өндрийн нарийвчлалыг багасгах, масштабыг томруулах байдлаар өөрчлөлт оруулахыг хориглоно.

10.4.Суурь орон зайн өгөгдлийг энэ хуулийн 5.4.1-т заасан бодлогын дагуу монгол улсын нутаг дэвсгэрийг хамруулан бүрдүүлнэ.

10.5.Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр бүрдүүлсэн орон зайн өгөгдлийг геоплатформд үнэ төлбөргүй төвлөрүүлнэ.

10.6.Орон зайн өгөгдлийн үнэн зөв байдлыг бүрдүүлсэн этгээд хариуцна.

### **11 дүгээр зүйл.Орон зайн өгөгдлийг боловсруулах**

11.1.Орон зайн өгөгдлийг боловсруулах гэдэгт түүнд математик боловсруулалт хийх, дүрслэх үйл ажиллагаа хамаарна.

11.2.Орон зайн өгөгдлийн боловсруулалт нь дараах шаардлагыг хангасан байна:

11.2.1.Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа солбицол, өндрийн нэгдсэн тогтолцоонд;

11.2.2.энэ хуулийн 7.1-т заасны дагуу мета-өгөгдлийг бүрдүүлсэн байх;

11.2.3.өргөтгөл, өгөгдлийн сан, мета-өгөгдлийн хувьд суурь орон зайн өгөгдөлтэй стандартын дагуу холбох боломжтой байх.

11.3.Орон зайн өгөгдлийг геопорталд дараах байдлаар дүрсэлнэ:



11.3.1.солбицлын жагсаалт;

11.3.2.тоон газрын зураг;

11.3.3.интерактив газрын зураг;

11.3.4.мультимедиа газрын зураг;

11.3.5.гурван хэмжээст загвар.

11.4.Энэ хуулийн 11.3.1-т зааснаас бусад орон зайн өгөгдлийн дүрслэл нь түүний эх өгөгдлийн нарийвчлал, хэрэглэх зориулалтад нийцсэн масштаб, нарийвчлал, агуулгатай байна.

11.5.Орон зайн өгөгдлийн боловсруулалтыг нээлттэй эх үүсгэвэр бүхий үйлдлийн системийн орчинд хийх эсхүл нээлттэй программ хангамж дээр үргэлжлүүлэн боловсруулах нөхцөлийг бүрдүүлнэ.

11.6.Орон зайн өгөгдлийг боловсруулах үйл ажиллагааг Монгол Улсын нутаг дэвсгэр дээрээс удирдаж, гүйцэтгэнэ.

11.7.Орон зайн өгөгдлийг боловсруулалтын аль нэг үе шатыг дотооддоо гүйцэтгэх боломжгүй гэж энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан зохицуулах хороо үзвэл тагнуулын байгууллагаас зохих зөвшөөрлийг авч тухайн үе шатны боловсруулалтыг гадаад улсын нутаг дэвсгэрээс удирдаж, гүйцэтгэж болно.

## **12 дугаар зүйл.Орон зайн өгөгдлийг хадгалах, хамгаалах**

12.1.Орон зайн өгөгдлийг хамгаалах гэдэгт тухайн өгөгдөл гэмтэхгүй, алдагдахгүй, гаднын халдлагад өртөхгүй байх нөхцөлд байршуулахад чиглэсэн үйл ажиллагаа хамаарна.

12.2.Үүлэн технологи, машины суралцах чадварт суурилан боловсруулсан өгөгдлийг шаардлагатай тохиолдолд физик төхөөрөмжид файл хэлбэрээр хадгалж болно.

12.3.Суурь орон зайн өгөгдлийг хадгалж буй программ хангамж, сүлжээ, техник хангамж бүхий дэд бүтэц төрийн хамгаалалтад байх ба түүний байрлал нь нууц байна.

## **13 дугаар зүйл.Орон зайн өгөгдлийг түгээх**

13.1.Орон зайн өгөгдлийг түгээх гэдэгт геоплатформоор дамжуулан энэ хуулийн 8.1-д заасан хандах эрхээр зохицуулагдсан орчинд өгөгдлийг нийтлэх, түгээх, солилцох үйл ажиллагаа хамаарна.

13.2.Суурь орон зайн өгөгдлийг геоплатформоор дамжуулан нэгдсэн байдлаар түгээх ба орон нутаг, улсын хэмжээнд гэсэн шатлалтай байж болно.

13.3.Орон зайн өгөгдлийг түгээхтэй холбогдсон шийдвэр нь энэ хуулийн 5.1-т заасан зарчимд нийцсэн байна.

## **14 дүгээр зүйл.Орон зайн өгөгдлийн хэрэглэх**

14.1.Орон зайн өгөгдлийг хэрэглэх гэдэгт тухайн өгөгдлийн үр өгөөжийг шууд ба шууд бус байдлаар хүртэх үйл ажиллагаа хамаарна.

14.2.Иргэн, хуулийн этгээд нь ашиг олох зорилгоор орон зайн өгөгдлийг хэрэглэхдээ энэ хуулийн 8.2-т заасан журмыг баримтална.

14.3.Орон зайн өгөгдлийг хэрэглэхдээ түүний эх сурвалжийг дурдсан байна.

14.4.Аливаа төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн орон зайд суурилсан бодлого, төлөвлөлт, шийдвэр, бүтээгдэхүүн, үйлчилгээ нь геоплатформд байршсан суурь орон зайн өгөгдөлд үндэслэсэн байна.

14.5.Энэ хуулийн 14.4-т заасныг зөрчиж, шийдвэр гаргасан бол албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болно.

14.6.Суурь орон зайн өгөгдлийг хууль бусаар олж авах, ашиглах, өөрчлөн ашиглах замаар ашгийн төлөө үйл ажиллагаа явуулсан иргэн, хуулийн этгээдийн холбогдох үйл ажиллагааг зогсооно.

14.7.Гамшиг, гэнэтийн ослын үед төрөөс иргэн, хуулийн этгээдийн эзэмшилд байгаа орон зайн сэдэвчилсэн өгөгдлийг Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу гаргуулан авна.

14.8.Монгол улсын иргэн, хуулийн этгээдийн дараах шалгуурын 3 ба түүнээс дээш үзүүлэлтийг хангаж буй орон зайн өгөгдөлд суурилсан ухаалаг үйлчилгээнд төрөөс дэмжлэг үзүүлж болно:

14.8.1.өөрийн хөрөнгөөр бий болгосон;

14.8.2.тухайн үйлчилгээгээр импортын зардлыг 30 хувиас дээш хэмнэж байгаа;

14.8.3.олон улсад өрсөлдөхүйц хэмжээнд хүрсэн;

14.8.4.боломжит дотоодын хэрэглэгчдийн 60-аас дээш хувь нь тогтмол ашиглаж байгаа;

14.8.5.үйлчилгээгээ нэвтрүүлснээр бүтээгдэхүүнийг эцсийн хэрэглэгчид хүргэх өртгийг 20 ба түүнээс дээш хувиар буруулсан.

14.9.Энэ хуулийн 14.8-д заасан иргэн, хуулийн этгээдэд төрийн дэмжлэгийг тэдгээрийн гаргасан саналыг харгалзан дараах хэлбэрээр үзүүлнэ:

14.9.1.төрийн зарим чиг үүргийг хариуцуулах;

14.9.2.хөнгөлөлттэй эсхүл хүүгүй зээлийг 2 хүртэл удаа олгох;

14.9.3.5 жилийн хугацаанд үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах урсгал зардлын 60 хувийг санхүүжүүлэх;

14.9.4.нөхөх олговортойгоор төрийн мэдэлд шилжүүлэх;

14.9.5.төрийн мэдлийн дэд бүтэц, үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг 5 жилийн хугацаанд үнэ төлбөргүй ашиглуулах.

14.10.Энэ хуулийн 14.9-д заасан шийдвэрийг Зохицуулах хороо гаргана.

### **15 дугаар зүйл.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн техникийн баримт бичгийн тогтолцоо**

15.1.Энэ хуулийн 10-13 дугаар зүйлд заасан үйл ажиллагааны техникийн зохицуулалтад Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 5.1, 8.1.1, Барилгын тухай хуулийн 5.1.1-т заасан баримт бичгийг ашиглана.

15.2.Техникийн баримт бичгийн төслийг боловсруулахдаа суурь орон зайн өгөгдлийг бүрдүүлэх асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авсан байна.

15.3.Техникийн баримт бичиг нь энэ хуулийн 5.1-т заасан зарчим, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээд нийцсэн байна.

15.4.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн удирдлага, зохион байгуулалтын шинжтэй журам техникийн баримт бичгийн тогтолцоонд хамаарахгүй.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ДЭД БҮТЦИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ, САНХҮҮЖИЛТ**

### **16 дугаар зүйл.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн зохицуулах хороо**

16.1.Монгол Улсын үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах, хөгжүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах, өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, иргэнийг шинэлэг, үнэн бодит, үр ашигтай үйлчилгээгээр хангах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр батлагдсан хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, Монгол Улсын олон улсын гэрээ, төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн зохицуулах хороо /цаашид “Зохицуулах хороо” гэх/ ажиллана.

16.2.Зохицуулах хорооны дүрмийг Засгийн газар батална.

16.3.Зохицуулах хороо нь дарга, гишүүд, нарийн бичгийн дарга гэсэн бүтэцтэй байх ба Засгийн газрын бүтцээс хамааруулан 9-13 гишүүнтэй байна.

16.4.Зохицуулах хорооны дарга, гишүүнийг Монгол Улсын Ерөнхий Сайд томилж, чөлөөлнө.

16.5.Зохицуулах хорооны дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байна. Зохицуулах хорооны гишүүдийн анхны томилгоог 2, 4, 6 жилээр хийж, цаашид 6 жилийн хугацаагаар томилно.

16.6.Зохицуулах хорооны гишүүд нь энэ хуулийн 6.4-т заасан өгөгдлийг бүрдүүлэх төрийн захиргаан төв байгууллагын бодлогын газрын дарга байна.

16.7.Зохицуулах хорооны даргаар газарзүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлал, газрын хэмжилт, зураглал, программ хангамжийн чиглэлээр дээд боловсролтой, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан Монгол Улсын иргэнийг томилно.

16.8.Зохицуулах хороо нь хуульд заасан зарим чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гэрээний үндсэн дээр бусдаар гүйцэтгүүлж болно.

16.9.Зохицуулах хороо нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.9.1.орон зайн өгөгдлийн дэд бүтцийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах;

16.9.2.орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах, хөгжүүлэх, түүний хэвийн үйл ажиллагааг хангах;

16.9.3.хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, нэмэх, өөрчлөх, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох нөхцөл, шаардлагыг тодорхойлсон журам батлах, мөрдүүлэх, холбогдох гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих;

16.9.4.сүлжээний шийдэл, хэрэглэгчийн тоног төхөөрөмжийг баталгаажуулах, холбогдох техникийн нөхцөл, шаардлагыг тодорхойлсон журмыг батлах, сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавих;

16.9.5.сүлжээ хооронд харилцан холболт хийх журмыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

16.9.6.үйлчилгээний хураамжийн хувь, хэмжээг батлах;

16.9.7.Зохицуулах хорооны төсөв, ажлын албаны бүтэц орон тоо, жилийн төлөвлөгөөг батлах;

16.9.8.шаардлагатай мэргэжлийн арга зүй, бодлогын чиглэлээр ажлын хэсэг байгуулах, зөвлөх үйлчилгээ авах, контрактын гэрээ байгуулах;

16.9.9.орон зайн өгөгдлийн дэд бүтцийг хөгжүүлэхтэй холбоотой хууль, тогтоомж, бодлого, стандарт, журмыг боловсруулах ажлыг зохион байгуулах;

16.9.10.эрх бүхий байгууллагыг зохих мэдээллээр хангах;

16.9.11.хууль, тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, эдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, зохицуулах хорооны шийдвэрийн биелэлтийг хангуулах;

16.9.12.орон зайн өгөгдлийн дэд бүтцийн оролцогч талуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

16.9.13.энэ хуулийн 16.9.1-т заасан чиг үүргийн хүрээнд Монгол Улсын олон улсын гэрээний төсөл боловсруулах, хэрэгжилтийг хангуулах;

16.9.14.хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуульд заасан журмыг батлах;

16.9.15.орон зайн өгөгдөл, мэдээлэлд суурилсан ухаалаг үйлчилгээ нэвтрүүлсэн иргэн, хуулийн этгээдийг шагнах, урамшуулах, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохицуулсан журмыг батлах, мөрдүүлэх, хяналт тавих;

16.9.16.тухайн жилд орон зайн өгөгдлийн дэд бүтцийн чиглэлээр хийсэн ажлыг тайлагнах;

16.9.17.төсвийн гүйцэтгэлийг тайлагнах;

16.9.18.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

16.10.Зохицуулах хорооны үйл ажиллагаа нь хурлын хэлбэртэй, шийдвэр нь тогтоол, тэмдэглэл, зөвлөмж хэлбэртэй байна.

16.11.Зохицуулах хорооны хурлыг нийт гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хүчинтэйд тооцно.

16.12.Зохицуулах хороо нь аливаа асуудлыг илээр, ердийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

16.13.Зохицуулах хорооны шийдвэрт дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

16.14.Зохицуулах хороо нь өдөр тутмын ажлыг уялдуулан зохион байгуулах ажлын албатай байна.

16.15.Зохицуулах хорооны нарийн бичгийн дарга нь ажлын албаны дарга байна.

16.16.Зохицуулах хороо, ажлын алба нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.

16.17.Ажлын алба нь орон зайн өгөгдлийн дэд бүтцийн талаар дараах чиг үүргийг хариуцсан нэгжтэй байна.

16.17.1.техникийн баримт бичгийн орчныг сайжруулах;

16.17.2.өгөгдөл хадгалалт, хамгаалалт;

16.17.3.өгөгдөл хуваалцах, түгээх;

16.17.4.инновац;

16.17.5.хүний нөөц;

16.17.6.бизнес загвар хөгжүүлэх.

## **17 дугаар зүйл.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааны санхүүжилт**

17.1.Суурь орон зайн өгөгдлийг бүрдүүлэх, боловсруулах үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

17.2.Орон зайн өгөгдлийн сэдэвчилсэн өгөгдлийг бүрдүүлэх, боловсруулах үйл ажиллагааг энэ хууль заасан үйлчилгээний хураамжаас олсон орлого, гадаад, дотоодын зээл тусламж, хувийн хөрөнгөөр санхүүжнэ.

17.3.Орон зайн өгөгдлөөр үйлчилсэн үйлчилгээний хураамжаас олсон орлогыг энэ хуульд заасан орон зайн өгөгдлийн дэд бүтцийг техник, технологийн хэвийн, найдвартай үйл ажиллагааг хангах, шинэчлэхэд чиглэсэн арга хэмжээнд зарцуулна.

## **18 дүгээр зүйл.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн улсын хяналт**

18.1.Орон зайн өгөгдлийн бүрдүүлэх, хамгаалах, түгээх, хэрэглэх ажиллагаанд хяналт тавих эрх бүхий улсын ахлах байцаагч, улсын байцаагч зохицуулах хороонд ажиллана.

18.2.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн улсын байцаагч нь мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэхдээ төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-д заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.2.1.энэ хуулийн **Error! Reference source not found.** дугаар зүйлд заасан хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, түдгэлзүүлэх талаар дүгнэлт гаргах;

18.2.2.энэ хуулийн 14.4-т заасныг зөрчсөн албан тушаалтанд хариуцлага тооцох, гаргасан шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох талаар дүгнэлт гаргаж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх.

## **ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД**

### **19 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

19.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

19.2.Энэ хуулийн 19.1-д зааснаас бусад тохиолдолд иргэн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

### **20 дүгээр зүйл.Хүчин төгөлдөр болох**

20.1.Энэ хуулийг 20.. оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## **ГАРЫН ҮСЭГ**

## **ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ДЭД БҮТЦИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар нь Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай хороог байгуулах, хуульд заасан журмыг боловсруулж, батлах, хууль тогтоомжийг сурталчлах, зохион байгуулалтын болон техник хэрэгсэл, санхүү, эдийн засгийн холбогдох арга хэмжээг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн дотор зохион байгуулна.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## **ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 12.13 дугаар зүйл нэмсүгэй:

“12.13 дугаар зүйл. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хууль зөрчих

1. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн 5.4.1, 5.4.3, 5.4.4, 5.5.1, 10.5, 10.6, 11.2, 11.6, 13.3, 14.4, 15.1-т заасныг, энэ хуулийн 8.2, 8.3, 16.9.4, 16.9.5, 16.9.10, 16.9.15-т заасан журмыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн 7.1, 9.3, 9.6, 10.2, 13.2, 13.7, 13.6, 13.8, 16.1-т заасныг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирлыг барагдуулж, хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## **ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.32 дах хэсэг нэмсүгэй:

“6.32. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 12.13 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан зөрчил.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## **ХАЯГЖУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлд “4.10. Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийг үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцээр дамжуулан нийтэд түгээнэ.” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Хаягжуулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтыг “Геоплатформоор дамжуулах боломжтой байх”, 3.1.5 дах заалтыг “Суурь орон зайн өгөгдлийн шаардлагыг хангасан байх” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### **ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл “Геодези, зураг зүйн тухай хуульд дор дурдсан агуулга бүхий 10<sup>1</sup> зүйлийг нэмсүгэй:

“ 10<sup>1</sup> дүгээр зүйл.Газрын зургийн солбицлын систем

10<sup>1.1</sup> Газрын зургийг солбицлын системээр нь тусгай болон иргэний гэж хоёр ангилна.

10<sup>1.1.1</sup> Тусгай болон иргэний солбицлын системийн хоорондох хөрвүүлэлтийн параметр нь төрийн нууцад хамаарна.

10<sup>1.1.2</sup> "тусгай солбицлын системд хийсэн газрын зураг нь улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангахад зориулагдана.

10<sup>1.1.3</sup> "Иргэний солбицлын системд хийсэн газрын зураг нь нээлттэй байна.

*10<sup>1.1.4</sup> "энэ хуулийн 10<sup>1.1.2</sup>-д заасан газрын зургийг иргэний хэрэгцээнд ашиглуулахаар геодези, зураг зүйн улсын нээгдсэн санд шилжүүлэн өгч болно."*

2 дугаар зүйл.Энэ хуулийг Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### **ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн “13.1.3.д батлан хамгаалах болон улсын хил хамгаалах зориулалттай болон энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл агуулсан байр зүйн зураг;” гэснийг “13.1.3.д Тусгай системд хийсэн газрын зураг;” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.